



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/155

Шивээговь сум

**Цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмж  
 нийлүүлэх ажлын гүйцэтгэлийг хүлээж авах  
 комисс томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай 2019 оны 271 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих “Цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх” ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

КОМИССЫН ДАРГА:

Ч.Сугармаа (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

Ц.Замбага (Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдаа авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Гишүүн:

Б.Даваадолгор (Цэцэрлэгийн эрхлэгч)

Э.Төрмандах (Соёлын төвийн эрхлэгч)

Д.Сувд-эрдэнэ (2-р багийн иргэн)

2. Цэцэрлэгийн тоног төхөөрөмжийг байгууллагын хөрөнгөнд бүртгэж, ашиглалт хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг цэцэрлэгийн эрхлэгч (Б.Даваадолгор)-т үүрэг болгосугай.

3. Гүйцэтгэлийн ажлыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлага хангасан тоног төхөөрөмж, бараа материалыг хүлээн авч, акт үйлдэн холбогдох баримтыг хавсарган хүлээлцэхийг комиссын дарга (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.



П.ГАНЧИМЭГ